63	3.29 Үндсэн чиглэл 2-18 Нисэхийн эцсийн автобусны буудлаас Буянт-Ухаа 21 дүгээр гудамж хүртэлх хатуу хучилттай 2.8 км авто замын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Зам тээврийн хөгжлийн яамны захиалгаар Нисэхийн эцсийн автобусны буудлаас Буянт-Ухаа 21 дүгээр гудамж хүртэлх хатуу хучилттай 2.8 км авто замын ажлын гүйцэтгэгчээр “Ди Вай Кэй Би” ХХК шалгарсан. Тус ажлын зургийг боловсруулж байгаа бөгөөд 06 сарын 20-нд газар шорооны ажлыг эхлүүлнэ.	40

64	3.30 Үндсэн чиглэл 2-19 Ривер Хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх хатуу хучилттай 1 км авто зам, зогсоол байгуулах ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Зам, тээврийн хөгжлийн яам тендерийн баримт бичгийг боловсруулж байна.	20
2.4.3 Явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.				
65	3.31 Үндсэн чиглэл 2-20 “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор явган хүний зам тавих ажлыг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 34 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажлын худалдан авах ажиллагааны эрх НЗД-ын 2019 оны А/376 дугаар захирамжаар ДЗД-д ирсэн. НАЗХГ-аас явган замын ажлын техникийн тодорхойлолтыг хүлээн авч 5 дугаар сарын 28-ны өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдсан. Нээлт 6 сарын 28-нд болно. Нийт төсөвт өртөг 357.0 сая төгрөг. Нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудлын зогсоол орчимд зөвшөөрөлгүй байршсан ТҮЦ-ийг буулгаж дугуйн зогсоол байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт төмөр хийцийн үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “ДИ ЮУ БИ БИ” ХХК-тай хамтарч “Дугуйн зогсоол” хийхээр ажиллаж байна. Мөн дугуйн зогсоол байрлуулах газрын байршлын судалгааг гаргах ажил хийгдэж байна.	60
2.4.4 Дүүрэгт авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбайг иж бүрнээр нь шийдвэрлэх замаар орон сууцны гаднах ил зогсоол, машины бөөгнөрлийн асуудлыг шийдэж оршин суугчдын ая тухтай байдлыг хангана.				
66	3.32 Үндсэн чиглэл 2-21 Шинээр хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол байгуулах байршлын судалгаа хийж, Хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах, шинээр байгуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	Судалгаа, тоо Ажлын явц, хувь	Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хангуулах ажлын хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх ажлын хүрээнд хот төлөвлөлт, дэд бүтэц, тохижилтын чиглэлээр 14 төрлийн нарийвчилсан судалгааны ажлыг 16 хороодоос авч нэгтгэсэн. Судалгааны нэгтгэлийн дүнд 2, 4, 6, 8 дугаар хороодоос бусад 12 хороодоос нийт 67658м2 бүхий 57 байршилд шинээр хийх шаардлагатай хүүхдийн тоглоомын мэдээлэл ирүүлсэн. Үүнд: 1 дүгээр хороо: 2 байршил, 3 дугаар хороо: 22 байршил, 5 дугаар хороо: 1 байршил, 7 дугаар хороо: 1 байршил, 9 дүгээр хороо: 3 байршил, 10 дугаар хороо: 1 байршил, 11 дүгээр хороо: 2 байршил, 12 дугаар хороо: 7 байршил, 13 дугаар хороо: 4	70

			байршил, 14 дүгээр хороо: 3 байршил, 15 дугаар хороо: 10 байршил, 16 дугаар хороо: 1 байршил Мөн шинээр авто зогсоол байгуулах шаардлагатай байршлын судалгаа авснаас 1, 2, 6, 8, 11 дүгээр хороодоос бусад 11 хорооноос нийт 19600м2 талбай бүхий 34 байршилд мэдээлэл ирүүлсэн. 3 дугаар хороо: 5 байршил, 4 дүгээр хороо: 1 байршил, 5 дугаар хороо: 1 байршил, 7 дугаар хороо: 2 байршил, 9 дүгээр хороо: 5 байршил, 10 дугаар хороо: 5 байршил, 12 дугаар хороо: 1 байршил, 13 дугаар хороо: 2 байршил, 14 дүгээр хороо: 6 байршил, 15 дугаар хороо: 4 байршил 16 дугаар хороо: 2 байршил 10-р хорооны 61,62-р байрны гадна талбай, 12-р хорооны байрны гадна талбай, 14-р хорооны урд талбай, 16-р хорооны БУЦС-ын урд талын талбайд байх хуучин тоглоомын талбайг шинэчлэн бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хэрэгжиж байна. Ажлын гүйцэтгэл 50 хувь.	
67	3.33 Үндсэн чиглэл 2-22 Жаргалант үйлчилгээний төвийн гадна талбайг үйлчилгээний стандартад нийцүүлэн засварлаж, тохижуулах ажлыг хийнэ.	Ажлын явц, хувь	19 дүгээр хорооллын Жаргалант үйлчилгээний төв орчмын тохижилтын ажлын зураг төсвийг “Скайлайн дизайн” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Барилгын хөгжлийн төв зураг, төсөвт магадлал хийж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувь	40
3.1.1 Арьс ширний үйлдвэрүүдийг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргах талаар авч хэрэгжүүлсэн шат дараатай арга хэмжээнүүдийг үргэлжлүүлж, үйлдвэрийн бохирдлыг бүрэн цэвэршүүлэх шинэ технологи нэвтрүүлнэ.				
68	3.34 Үндсэн чиглэл 3-1 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй арьс ширний үйлдвэрүүдийн бохирдлыг цэвэршүүлэх чиглэлээр судалгаа хийж холбогдох байгууллагуудтай хамтран шинэ технологи нэвтрүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна.	Судалгааны ажлын явц, хувь	Нийслэлийн байгаль орчны газраас дүүргийн 3-р хорооны зүүн талд Чингисийн өргөн чөлөөний 22, 23 дугаар байрны дунд хэсэгт, Шарав 43,43а байрны зүүн талд 2 газарт сүүлийн үеийн дэвшилтэт технологиор хөрсний бохирдлыг саармагжуулж, мод, бут сөөг тарьж зүлэгжүүлэлт хийж байна.	50
ГУРАВ. ЭКО ДҮҮРЭГ-НОГООН ХӨГЖИЛ				
3.1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.				
69	3.35 Үндсэн чиглэл 3-2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулж урамшуулах журам	Боловсруулсан журам, тоо	Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулж урамшуулах журмын төсөл боловсруулагдах шатандаа явж байна.	30

	боловсруулж, сурталчилах, хэргэжилт хангах ажил зохион байгуулна..			
3.1.3 Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулж хариуцлагыг дээшлүүлнэ.				
70	3.36 Үндсэн чиглэл 3-3 Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын судалгаа гарган, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийнэ.	Хяналт, шалгалт, тоо	Монгол Улсын Шадар сайдын баталсан “Үйлдвэрийн барилга байгууламжинд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт”-ыг удирдамжийн дагуу дүүргийн Прокурорын газар, Онцгой байдлын хэлтэстэй хамтран хяналт шалгалт зохион байгуулсан.	50
71	3.37 Үндсэн чиглэл 3-4 Байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, нөхөн сэргээлтэд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.	Хяналт, шалгалт, тоо	Нийслэлийн Байгаль орчны газар, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарч байгаль орчны нөхөн сэргээлтэд 6 удаа хяналт, шалгалт хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/77 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, давхардсан тоогоор нийт зөрчил гаргасан том оврын авто машины 2330 жолоочид 32.4 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулж зөрчлийг арилгуулсан.	70
3.2.1 Дүүргийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.				
72	3.38 Үндсэн чиглэл 3-5 Хөрсний бохирдол ихтэй газруудын ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг үе шаттайгаар хийж, иргэд, оршин суугчдад сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна.	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо	Дүүргийн 2, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны гэр хороололд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх шаардлагатай 13062 өрхийн нүхэн жорлон, бохирын цооногийн судалгааг УБЗАА-д хүргүүлж 16 дугаар хорооны 2183 айл өрхийн 1461 жорлон, 1090 бохирын цооног ариутгах ажлын төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн. Дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 11, 15 дугаар хороодын хогийн цэг, ил задгай бие зассан булан тохой, бохирын худаг хальсан зэрэг хөрсний бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн зам талбайн 69 байршилд хэсэгчилсэн ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/202 дугаар захирамжаар “Эрүүл хөрс – Эрүүл орчин” аяныг эхлүүлсэн. Аяны хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд “Хөрсөө хамгаалъя” өдөрлөгийг 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодод зохион байгуулсан.	100
3.2.2 Агаарын бохирдлыг бууруулах ногоон технологи нэвтрүүлнэ.				

73	3.39 Үндсэн чиглэл 3-7 Байгальд ээлтэй техник технологийг сурталчлан хороодын зорилтот бүлгийн өрхүүдэд ногоон технологи бүхий цахилгаан халаалт олгох ажил зохион байгуулна.	Олгосон цахилгаан халаалт, тоо	Хороодын зорилтот бүлгийн 123 өрхийн судалгааг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт хүргүүлсэн.	30
3.2.3 Агаарын бохирдол үүсгэгч гэр хорооллын зуух, авто машины утаа, нам даралтат зуух зэрэг гол эх үүсвэрүүдийг хүний эрүүл мэндэд хортой байдлаар нь эрэмбэлэн тогтоож, эрүүл мэндэд хамгийн их хор хүргэж буй эх үүсвэрт анхаарал хандуулж ажиллана.				
74	3.40 Үндсэн чиглэл 3-8 Дүүргийн төсөвт байгууллагуудын халаалтыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Дүүргийн 7,8 дугаар хорооны 60, 118 сургууль, 73, 209 дүгээр цэцэрлэгийг төвлөрсөн шугамд холбох ажил 80%-тай явагдаж хийгдэж байна.	80
3.2.4 Иргэдэд экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлнэ.				
75	3.41 Үндсэн чиглэл 3-9 Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдэд экологийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт, тоо	"Хуульч эмэгтэйчүүдийн холбоо", "People in Need" олон улсын ТББ-тай хамтарч 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодын иргэдэд Түүхий нүүрсийг хориглосон тухай, Дотоод орчны бохирдол сэдэвт сургалтыг 4 удаа зохион байгуулж нийт 375 иргэнийг хамруулсан. "Таван толгой түлш" улсын үйлдвэртэй хамтарч 4, 5, 6, 7, 9, 10, 16 дугаар хороодод "Сайжруулсан түлшний онцлог" сэдэвт сургалтыг 7 удаа зохион байгуулсан. Засгийн газрын 62-р тогтоолтой холбоотой "Агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе" чуулганд 384 иргэн 124 хэсгийн ахлагчийг хамруулан оролцуулсан. Иргэдэд хөрсний бохирдлын талаар мэдээлэл зөвлөгөө хүргэх, нүхэн жорлонгийн стандартыг танилцуулах, хотын суурьшлын бүсийн хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийн хооронд "Хөрсөө хамгаалъя" өдөрлөгийг 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодод зохион байгуулж ажилласан.	80
3.2.5 Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжуудын нөхцөл байдлыг стандартын шаардлагад нийцүүлнэ.				
76	3.42 Үндсэн чиглэл 3-10 Стандартын шаардлага хангахгүй байгаа сургууль, цэцэрлэгүүдийн ариун цэврийн байгууламжуудыг төвлөрсөн шугамд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Наадамчдын зам дагуу төв магистраль шугам, 6 дугаар хорооны Яармаг 6-р гудамжаар 600 м дулааны шугам татах ажлууд холболтын шатандаа явагдаж байна.	50

3.3.1 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашааны стандарт, жишгийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ.				
77	3.43 Үндсэн чиглэл 3-11 Хороодод гэрэлтүүлэг болон хайс хашлаганы батлагдсан стандарт жишгийг мөрдүүлж, шинэчлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хайс хашлагыг шинэчлэх, засварлах ажлын хүрээнд хяналт шалгалтыг хэсэгчлэн 2 удаа зохион байгуулж, засварлах шаардлагатай 36 байршлын 4494 урт метр хайс, хашлага, шинээр хийх шаардлагатай 32 байршлын 16123 урт метр хайс хашлагын судалгааг гаргасан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд ажиллах тухай албан мэдэгдлийг 1-16 хороонд 2019 оны 05 сарын 22-ний өдрийн 09/995 дугаар бичгээр хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд ашиглагдахгүй удсан 3 дугаар хорооны 43 дугаар байрны урд байрлах хашаа болон 52 дугаар сургуулийн урд хашааг буулгаж газар чөлөөлөх арга хэмжээ авч ажилласан.	50
3.2 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.				
78	3.44 Үндсэн чиглэл 3-12 Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн хөл газрын ургамлыг хадах, тайрах, тархалтыг бууруулах арга хэмжээнд иргэд, ААНБ-уудын оролцоог нэмэгдүүлж, цэвэрлэгээг үе шаттайгаар зохион байгуулна.	Харшлын өвчин үүсгэгч ургамлын цэвэрлэгээний давтамж, тоо	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/145 дугаар тушаалын дагуу “Шарилжгүй Улаанбаатар – 4” аяныг дүүргийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан бэлтгэл ажлыг хангаж байна. Аяны нэгдсэн зохион байгуулалт бүхий эхний арга хэмжээ 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдана. 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр 11-р хорооны Бурхантай хөшөөтэй цэцэрлэгт хүрээлэнгийн 16700 м.кв зүлэгт талбайн өнжмөл шар өвс, шарилжийг хадаж 32,5 м.куб хог хаягдлыг 13 рейсээр зөөж тээвэрлэсэн.	80
3.3.3 Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ.				
79	3.45 Үндсэн чиглэл 3-13 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбайг хашаажуулах, иргэн, ААН-ийн оролцоотойгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.	Нэмэгдсэн ногоон байгууламжийн хэмжээ, тоо Ажлын явц хувиар	Бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээнд 129 өрх, 2316 иргэн 385 мод, 863 аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран нийт 11898 ширхэг мод, бут, сөөг тарьсан. Энэхүү ажлын хүрээнд 10 дугаар хорооны буянт ухаа СӨХ-ны хамт олон 64-р байрны 50 метр урт хайс, 3 дугаар хороо 4 дүгээр байрны гадна 30 метр урт ногоон байгууламжийн хайс хашлагыг шинээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	60
3.3.4 Дүүргийн тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно.				
80	3.46 Үндсэн чиглэл 3-14 Нийтийн эзэмшлийн шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлэх, хатуу хучилттай зам талбай байгуулах ажил зохион байгуулна.	Зүлэгжүүлсэн талбай, м2	Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбай болон орон сууц хороолол дунд зүлэгжүүлэх шаардлагатай 102419 м2 талбай, хатуу хучилттай болгох шаардлагатай 137684 м2 талбайн судалгаа гаргасан. Энэхүү ажлын хүрээнд иргэд аж ахуйн нэгж байгууллагын оролцоотойгоор 800м2 талбайг зүлэгжүүлэх ажил хийгдэж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	80

			Морингийн даваанд 1.2 км хатуу хучилттай авто зам хийх ажил хийгдэж байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн 34 байршлын 7797м2 талбайд шинээр явган зам хийхээр төлөвлөсөн. 2019 оны 05 сарын 15-ний дүүргийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж 2019 оны 05 сарын 28-ний өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдсан.	
3.3.5 Гэр хорооллын зам талбайг цардмалжуулах, шаардлагатай хэсгүүдийг чулуун хучилттай болгох ажлуудыг хороодын иргэдийн бүлэг, бизнес нөхөрлөлүүдээр гүйцэтгүүлнэ.				
81	3.47 Үндсэн чиглэл 3-15 Гэр хорооллын шороон хөрс бүхий нийтийн эзэмшлийн зам талбайд явган зам тавих ажлыг үргэлжлүүлнэ.	Явган зам, км	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Морингийн даваанд 1.2 км хатуу хучилттай авто зам хийх ажил хийгдэж байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн 34 байршлын 7797м2 талбайд шинээр явган зам хийхээр төлөвлөсөн. 2019 оны 05 сарын 15-ний дүүргийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж 2019 оны 05 сарын 28-ны өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдсан.	80
3.3.6 Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна.				
82	3.48 Үндсэн чиглэл 3-16 Дунд голын дагуу амралт, чөлөөт цагаа өнгөрөөх амралтын бүс байгуулах ажлын судалгаа хийнэ.	Байршлын судалгааны явц ,хувь	Туул голын эрэг дагуу эко зурвас байгуулах ажлын зураг төсвийг “Скайлайн дизайн” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Барилгын хөгжлийн төв зураг, төсөвт магадлал хийж байна.	30
3.3.7 Мод тарьсан, ногоон байгууламж бий болгосон иргэд, байгууллагыг урамшуулах тогтолцоог оновчтой зохион байгуулна.				
83	3.49 Үндсэн чиглэл 3-18 Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх талаар идэвхи санаачлага гаргасан иргэн, ААНБ-уудыг урамшуулах журам боловсруулж, сурталчлан хэрэгжилтийг ханган ажиллана.	Шинээр батлагдсан журам, тоо	Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоо идэвх санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын уриалга гарган ажилласан. Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагатай хамтран мод үржүүлгийн талбайд очиж мод тарих арга, аргачлал, арчлалт хамгаалалтыг хэрхэн хийх талаар зөвлөгөө өгч практик сургалт зохион байгуулж гарын авлага тараасан. Сургалтад 30 иргэнийг хамруулсан. Энэхүү ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас “Манай хороо-Миний гудамж” аяныг 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс 10 сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулж гадна талбайгаа тохижуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгаруулах уралдааны зохион байгуулахаар төлөвлөн удирдамж, урамшуулах журмыг боловсруулан ажиллаж байна.	80
3.3.8 Нийтийн зам талбайн бохирдол, хог хаягдлын хяналт, удирдлагын шинэ менежментийг нэвтрүүлнэ.				

84	3.50 Үндсэн чиглэл 3-19 Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төслийг 1, 2, 3 дугаар хороонд хэрэгжүүлнэ.	Хог хаягдал ангилан ялгах төсөл хэрэгжүүлэх хороо, тоо	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж, ангилан ялгаж хэвшье аяны хүрээнд 1,2,3 дугаар хороонд байгуулсан ангилагдсан, дахивар хог хаягдлыг тээвэрлэх 13 цэгийн үйл ажиллагааг сайжруулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн төвийн гадна талбайд бага оврын ангилан ялгах 3 өнгийн хогийн савыг шинээр суурилуулсан. 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч сурагчдад хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр мэдлэг олгох “Эко аялал”-ыг зохион байгуулсан.	80
3.3.9 Дүүргийн тохижилт, архитектор-дизайн шийдлийг нэгдсэн бодлогоор хангах бүтэц бий болгон хэрэгжүүлж ажиллана.				
85	3.51 Үндсэн чиглэл 3-20 Дүүргийн ЗДТГ-ын батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан архитектор-дизайны мэргэжилтний орон тоог нэмэгдүүлнэ.	Нэмэгдэх орон тоо	Дүүргийн ЗДТГ-ын батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэст Хот төлөвлөлт, судалгаа хариуцсан ажилтныг томилж орон тоог нэмэгдүүлсэн.	100
86	3.52 Үндсэн чиглэл 3-21 Хороодын нэг цэгийн үйлчилгээний тохижилт, хаягжуулалт, гадна фасадны дизайныг нэгдсэн нэг стандарттай болгох ажлыг үргэлжлүүлнэ	Хороо, тоо	НХБХГ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар ажлын даалгавар дэмжигдсэн. Зураг төсвийг гүйцэтгүүлэн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн, 2019 оны 05 сарын 28-ны өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдсан бөгөөд 06 сарын 28-нд нээлт хийнэ.	40
3.3.10 Хог хаягдал үүсгэж, гудамж талбай бохирдуулах аливаа үйлдэлд хатуу хяналт тавьж шийдвэрлэж байх үүднээс дүүргийн байгууллага, албан газруудтай харилцан ойлголцлын гэрээ байгуулж, ахмад залуу үеийнхнээс бүрдсэн эргүүлийн баг ажиллуулан хамтарч ажиллана.				
87	3.53 Үндсэн чиглэл 3-22 "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам"-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих Эко эргүүлийн багийг хороодод ажиллуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Дүүргийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулдаг 409 аж ахуйн нэгж байгууллагуудтай 1-16 хороо "Тохижилт цэвэрлэгээний гэрээ"-г байгуулан орчны 50 метрийн зураглал гарган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүдийн оролцоотой 800м2 талбайг зүлэгжүүлж, 12000 мянга ширхэг мод бут сөөг тарьж, 30 урт метр хайс хашлага, 356 урт метр явган замыг засварлах шинэчлэх ажлыг хийж гадна талбайн тохижилтыг сайжруулан ажилласан	80
3.3.11 Дүүргийн хэмжээн дэх зам талбай, олон нийтийн эзэмшлийн газруудад мөрдөгдөх аюулгүйн зааварчилгаа, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулна.				
88	3.54 Үндсэн чиглэл 3-23 Засварлах шаардлагатай нийтийн эзэмшлийн талбай, сургууль, цэцэрлэг, орон сууцны хороолол дундах замын тэмдэг тэмдэглэгээний судалгаа гарган засварлах, явган хүний зам, авто замын	Судалгаа, тоо	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай болон орон сууцны хороолол дундах засварлах шаардлагатай 68 замын тэмдэг, шинээр хийх шаардлагатай 64 замын тэмдэг тэмдэглэгээ мөн засварлах болон шинээр хийх шаардлагатай 49 анхааруулах самбарын судалгаа гаргасан. Энэхүү ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар явган хүний зам, авто замын	90

	уулзваруудад байр зүйн тэмдэглэгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.		уулзваруудад байр зүйн тэмдэглэгээ хийх ажил гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зарлагдсан.	
3.3.12 Нийтийн эзэмшлийн зам талбай, хороолол дундах замын тэмдэглэгээ, хаягийн стандартыг мөрдүүлж ажиллана.				
89	3.55 Үндсэн чиглэл 3-24 Стандартын шаардлага хангаагүй нийтийн эзэмшлийн зам талбай, хороолол дундах замын тэмдэглэгээг засварлуулах, шинэчлэх ажлыг ААНБ, иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Нийтийн эзэмшлийн талбай, сургууль, цэцэрлэг, орон сууцны хороолол дунд засварлах шаардлагатай 68 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээ, 31 ширхэг анхааруулах самбар, шинээр хийх шаардлагатай 64 ширхэг замын тэмдэг, 18 ширхэг анхааруулах самбар байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоотойгоор 18 дугаар сургуулийн хажууд байрлах 2 ширхэг тэмдэг тэмдэглэгээг засварласан.	50
ДӨРӨВ. АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ				
4.1.1 Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургуулийн барилгыг өргөтгөх буюу шинээр барьж, сургуулиудыг хоёр ээлжид бүрэн шилжүүлнэ.				
90	3.56 Үндсэн чиглэл 4-1 Дүүргийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудын барилгыг шинээр барих буюу өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, 118 дугаар сургуулийн өргөтгөл, Буянт-Ухаа 2 хороололд шинэ сургуулийн барилга барих ажлуудыг эхлүүлнэ.	Нэмэгдэх суудал, тоо	БУЦС-ийн 640 суудалтай өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Жинсийн орой" ХХК ажиллаж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 60 хувьтай байна. 9-р хорооны 114-р сургуулийн 320 суудалтай өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Содон номин" констракшн ХХК ажиллаж байгаа бөгөөд барилгын суурийн ажил эхэлсэн. 52 дугаар сургуулийн 320 суудалтай өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Эм Жи Эл Би" ХХК ажиллаж байгаа бөгөөд давхарлан барих 3 давхрын төмөр карказ угсрагдаж дууссан. Блок өрөх ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 50%, 118 дугаар сургуулийн барилгын ажлын сонгон шалгаруулалт зарлагдсан.	40
4.1.2 Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө.				
91	3.57 Үндсэн чиглэл 4-2 Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэгийн барилгыг барих буюу өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, 12, 189 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 121, 134 дүгээр цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих ажлуудыг эхлүүлнэ.	Нэмэгдэх ор, тоо	12 дугаар цэцэрлэгийн барилгын ажлын хяналтын төсвийг батлагдсан төсөвт багтаан өөрчлөлт оруулж, 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарласан. 189 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөв боловсруулах даалгавар, ажлын зургийн хуулбарыг НХОГ-аас авч, 5 сарын 22-ны өдөр ХААА-нд хүлээлгэн өгсөн. Тендерийн нээлт 2019 оны 07 сарын 03-нд болно. 121-р цэцэрлэгийг буулгаж дахин барилгажуулах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 4 дүгээр сарын 23-нд зарлагдаж 5 сарын 23-нд нээлт хийсэн. 134 дүгээр цэцэрлэгийн 240 ортой барилгыг буулгаж шинээр барих ажлын тендер зарлагдсан.	40
92	3.58 Үндсэн чиглэл 4-4	Байгуулсан төв, тоо	Хүүхэд харах үйлчилгээний стандарт шаардлагыг хангасан дүүргийн 2, 5, 10 дугаар хорооны 3 иргэнд ажлын байрны дүгнэлт	100

	Хүүхэд харах үйлчилгээний төвүүдэд зөвлөн туслах нэгжийг хороодын дэргэд байгуулна.		болон холбогдох бичиг баримтыг үндэслэн “Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл”-ийг олголоо. Ингэснээр 2018-2019 оны хичээлийн жилд дүүргийн хэмжээнд 62 хүүхэд харагч 312 хүүхдийг асран хамгаалах үйлчилгээ үзүүллээ.	
4.1.4 Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбайг шинээр барьж байгуулна.				
93	3.59 Үндсэн чиглэл 4-5 Хуучин тоглоомын талбайг засварлах, гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбай байгуулах ажлыг үргэлжүүлнэ.	Шинээр байгуулах тоглоомын талбай, тоо засварын ажлын явц, хувь	10-р хорооны 61,62-р байрны гадна талбай, 12-р хорооны байрны гадна талбай, 14-р хорооны урд талбай, 16-р хорооны БУЦС-ын урд талын талбайд байх хуучин тоглоомын талбайг шинэчлэн бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хэрэгжиж байна. Ажлын гүйцэтгэл 50 хувь.	70
4.1.5 Авто машины төвлөрөл ачааллыг бууруулах, нийтийн тээврийн соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс дүүрэгт Сургуулийн автобус, Богино эргэлтэт шуурхай автобус-ыг бий болгож үйлчилгээнд нэвтрүүлнэ.				
94	3.60 Үндсэн чиглэл 4-6 Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийг хүүхдийн автобустай болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, 10, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр автобусны буудал байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.	Уламжлах ажлын явц, хувь Автобусны буудал байгаагаа хороо, тоо	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн боловсролын газарт дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран албан тоот явуулсан. Нийслэлийн боловсролын газраас хөрөнгийг шийдэж, 10-р сургуульд автобус хүлээлгэн өгөхөөр болсон. “Монгол машин байгууламж” ХХК угсарч байгаа бөгөөд 7 сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. 10, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр автобусны буудал байгуулах ажил 2018-2019 онд он дамжин хэрэгжсэн бөгөөд 05 сарын 15-ны өдөр ажил бүрэн дуусч техник хяналтын комисс ашиглалтад хүлээн авсан.	40
95	3.61 Үндсэн чиглэл 4-8 7 дугаар хорооны 60-р сургуулийн гадна талбайд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай байгуулах, сургууль, цэцэрлэгийн гадна талбайд тохижилт хийх ажлыг үргэлжүүлнэ.	Спорт талбай, тоо	НХБХГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар дэмжигдэж ажлын даалгавар баталгаажсан. 2019 оны 05 сарын 01-нд тендер зарлагдсан. 06 сарын 03-нд нээлт хийсэн.	40
4.2.1 Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.				
96	3.62 Үндсэн чиглэл 4-10 Хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэл болон хүндрэлээс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд аян өрнүүлэн дүгнэж, урамшуулна.	Өвчний илрүүлэг, хувь	1. Хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэл болон хүндрэлээс сэргийлэх сургалтыг 12 удаа хийж 170 үйлчлүүлэгч хамрагдсан. 2. "Эрүүл иргэн аян"-ыг зохион байгуулах дүүргийн Засаг даргын 2019 оны А/155 дугаар захирамж гарч эрт илрүүлгийн ажил явагдаж байна. Одоогоор 15 хорооны Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа 14790 буюу 35%, чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа 12898 буюу 30,5% хамрагдсан. Үүнээс артерийн даралт илэрсэн 43, чихрийн шижин	70

			илэрсэн 2 иргэнийг шаардлагатай шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх ажил явагдаж байна. 3. Дүүргийн Эрүүл мэндийн төвд чихрийн шижин, цусны даралтыг илрүүлэх зорилгоор 1 цэгийн үйлчилгээг нээн ажиллуулж байна.	
97	3.63 Үндсэн чиглэл 4-11 Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулж, урамшуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	“Оном” сантай хамтран ХУД-ийн ӨЭМТ-үүдийн дэргэдэх сайн дурын идэвхтнүүдийг чадваржуулах, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөхөд бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтаар сайн дурын идэвхтнүүд даралт хэмжих аргад суралцаж, даралт ихэссэнээс учир болох аюулын талаар мэдээлэл авсан. Сургалтанд нийт 56 сайн дурын идэвхтэн хамрагдсан.	80
4.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.				
98	3.64 Үндсэн чиглэл 4-12 Дүүргийн ЕБС, цэцэрлэгүүдийн эмч, эцэг эхчүүд, сурагчдын дунд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, "Эрүүл шүд" аян өрнүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, сургагч багш бэлтгэх сургалтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Амны хөндийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, АШУҮИС-ийн багш нартай хамтран зохион байгууллаа. Сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч 100 хүнийг хамруулан гарын авлагаар хангасан. Амны хөндийн үзлэг оношилгоонд 5 цэцэрлэгийн 2286 хүүхэд, 8 сургуулийн бага ангийн 7492 сурагч нийт 9778 суралцагчдыг хамруулж зөвлөгөө өгсөн байна.	100
4.2.3 Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, өртөмтгий бүлгийн иргэдийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 1 удаа оруулж эмчилгээний хамрагдалтыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэн өвчлөлийн төвшинг бууруулах арга хэмжээ авч ажиллана.				
99	3.65 Үндсэн чиглэл 4-13 Сүрьеэ өвчний талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэг хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	Дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/78 дугаар захирамжаар сүрьеэгийн дэгдэлтийн үед ажиллах салбар дундын хамтарсан ажлын хэсгийг байгуулж 5 удаа хуралдсан. Хурлаар сүрьеэгийн эрт илрүүлэгийн ажлыг эрчимжүүлэх, халдвар илэрсэн өвчтөнүүдийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 9,000,000 төгрөгийг гаргаж 15 дугаар сургуулийн 30 ангид ариутгалын гэрлийг авч суурилуулах, хоол хүнс, витаминжуулалтыг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. 2019 оны эхний 5 сарын байдлаар Ерөнхий боловсролын 7, 15, 26, 32, 60, 115, 130-р сургууль, 1 цэцэрлэг нийт 8 хүүхдийн байгууллагын 2914 багш, сурагчдыг ойрын хавьтлын идэвхтэй илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулж, халдвартай	80

			<p>хэлбэрийн сүрьеэтэй 2, эмнэлзүйгээр 37, эмэнд тэсвэртэй сүрьеэ 1 тохиолдол илрүүлж хяналтанд авсан.</p> <p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх сүрьеэ судлалын мэргэжлийн салбар зөвлөл, ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 15-р сургуулийн 529хүүхдийг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах үйл ажиллагаатайг ХӨСҮТ-тэй хамтран зохион байгуулж байна. Хүүхдийн байгууллага, иргэд, өвчтөний ар гэрийнхэнд “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сургалт мэдээлэл сурталчилгаа, өдөрлөг, АХА тэмцээн, зурагт хуудас тараах, танхимын сургалт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр яриа таниулга хийх зэрэг хэлбэрээр зохион байгуулж 2020 иргэнийг хамруулж, 5 төрлийн 1450 гарын авлага, 200 амны хаалт тарааж, сургалт сурталчилгааг хийлээ. Эмийн компаниудтай хамтран өдөрлөг зохион байгуулж сургалтанд оролцсон иргэдэд 4 төрлийн 200 ширхэг витамин тараасан. Мөн дүүргийн ГБХЗХХ, АБНТБХ-тэй хамтран сургалтуудыг зохион байгуулж байна. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 2019 оны эхний 4 сарын байдлаар 65 тохиолдол, 10000 хүн амд 3,7 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 тохиолдол, 10000 хүн амд 2,0 промилоор буурсан байна.</p>	
100	<p>3.66 Үндсэн чиглэл 4-14 Орон гэргүй болон орц, хонгилд амьдарч байгаа иргэдийг урьдчилан үзлэгт хамруулна.</p>	Хамрагдалт, хувь	<p>“Гэртээ харих зам” дэд хөтөлбөрийг 2019 онд Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд 21 ажлыг хэрэгжүүлэхээр тусгаснаас хагас жилийн байдлаар 12 ажил хэрэгжсэн.Хөтөлбөрийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй орон гэргүй болон орц, хонгилд амьдарч байгаа нийт 92 иргэнийг сүрьеэгийн болон ДОХ/БЗХӨ, дотор, мэдрэл, сэтгэц, зүрх судасны үзлэг шинжилгээнд хамруулсан.Мөн эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах, иргэний бүртгэлийн зөрчил тодорхойлон бичиг баримт олгох, халуун хоол цай, хувцас өгсөн. Тус арга хэмжээг дүүргийн Эрүүл мэндийн төв, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улаан загалмай хороотой хамтран зохион байгуулаа.</p>	50
4.2.4 Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.				
101	<p>3.67 Үндсэн чиглэл 4-15 Яармагийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.</p>	Тоног төхөөрөмж, тоо	<p>Яаралтай тусламж, хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт нэн шаардлагатай байгаа тарианы шахуурга, дуслын автомат шахуурга, суурь бүхий хяналтын монитор зэрэг 4 нэр төрлийн 19 ширхэг 33 сая төгрөгний эмнэлгийн тоног төхөөрөмж олгосон. ЭМЯ-ы хөрөнгө оруулалтаар хүүхдийн Цахилгаан ПАМП 3ш, Дусал тохируулагч 2 ш тус тус хангагдсан. НЭМГазарт хүүхдийн</p>	100

			тусламж үйлчилгээнд шаардлагатай 12 нэр төрлийн 76.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийн захиалга өгөгдсөн. Дүүргийн санхүүжилтээр тарианы шахуурга 2 ширхэг, пульсоксиметр 2 ширхэгийг нийлүүлсэн.	
102	3.68 Үндсэн чиглэл 4-16 Хэвтэн эмчлүүлэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлгийн гадна зам, талбайн тохижилтын ажлыг хийнэ.	Ажлын явц, хувь	Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх НЗД-ын 2019 оны А/298 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд шилжин ирсэн. Тендерийн баримт бичиг боловсруулагдаж байна.	30
103	3.69 Үндсэн чиглэл 4-18 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлах, цогц арга хэмжээ зохион байгуулна	Сургалт, тоо	Эрүүл мэндийн яамнаас 2019 оныг “Инээмсэглэл-Эерэг хандлага” уриаг хэрэжүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор “Эмнэлэгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт 2 кредитын сургалт, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжлийн холбоо, дүүргийн ЭМТ-өөс зохион байгуулсан “Антибиотикийн зохистой хэрэглээ” практикт”, “Хүүхдийн амьсгалын эрхтний эмгэгийн оношлогоо” сургалтад 16 өрхийн эрүүл мэндийн төвийн нийт эмч мэргэжилтнүүд хамрагдсан.	40
4.2.5 Хороодын өрхийн эмнэлгүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд анхаарч материаллаг бааз, хүний нөөцийн ур чадвар, боловсон хүчний орон тоо, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.				
104	3.70 Үндсэн чиглэл 4-17 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт ӨЭМТ-ийн барилгын ажлыг эхлүүлэх," Эрүүл мэндийн төв"-ийн Яармаг салбар, 6-р хорооны "Чанд авиа" ӨЭМТ-ийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. .	Ажлын явц, хувь	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барихад шаардагдах газрыг дүүргийн ЗД-ын 2019 оны А/89 дүгээр захирамжаар олгосон бөгөөд дээрх газрын захирамжийг НЗД-ын захирамж болгох хүсэлтийг НГЗБА-нд 06/923 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ЭМТ-ийн Яармаг салбар, 6-р хорооны “Чанд авиа” ӨЭМТ-ийн барилгын засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 5 сарын 29-нд зарлагдсан.	30
105	3.71 Үндсэн чиглэл 4-19 15 дугаар хорооны ӨЭМТ-д автомашин худалдан авах , 8 дугаар хорооны ӨЭМТ-ийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Нийлүүлсэн машин, тоо Ажлын явц, хувь	15-р хорооны ӨЭМТ-д автомашин нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолтыг НЭМГ-ын 2/431 тоот албан бичгээр хүлээн авч дүүргийн ХААА-нд хүлээлгэн өгсөн. Тендерийн баримт бичиг боловсруулагдаж байна.	40
4.2.6 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх тал дээр төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.				
106	3.72 Үндсэн чиглэл 4-20 Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран олон нийтэд чиглэсэн соёл, спортын арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	2019 оны эхний хагас жилийн байдлаар "Сагсан бөмбөгийн холбоо", "Монголын Волейболын холбоо, "Их талын дуулиан" ТББ, Монголын даамны холбоо, Монголын хүндийг өргөлтийн холбоо, "Архинаас амирлахуй" ТББ , "Олимпус" "Супер спиннинг" фитнес клуб зэрэг 15 байгууллагатай хамтран 18 нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулан 2800 иргэнийг хамруулсан.	50

4.3.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлнэ.				
107	3.73 Үндсэн чиглэл 4-21 Оюутан, сурагчдын хотын соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулна.	Сургалт, тоо	1. Дүүргийн Соёлын ордны авьяас хөгжүүлэх дугуйлангийн сурагчид Чингэлтэй дүүргийн сурагчдын клубтэй хамтран дүүргийн ЕБС-ийн сурагчдад хотын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр “Хотын Соёл”, “Соёлтой иргэн би” сэдвээр нөлөөллийн ажлуудыг зохион байгууллаа. Үйл ажиллагаанд нийт 1000 гаруй сурагч, оюутан залуус хамрагдсан. 2. Хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчинг бүрдүүлэн оюутан залуус, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулан “Хотын соёл биднээс эхэлнэ” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Нийт 7 сургуулийн 1360 хүүхэд, оюутан залуус хамрагдсан байна.	100
108	3.74 Үндсэн чиглэл 4-22 Иргэд, хүүхэд залуучуудын дунд “Хотын соёл-Хоггүй дүүрэг” олон нийтийн аян өрнүүлнэ.	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	“Хотын Соёл-Хоггүй дүүрэг” олон нийтийн аяны хүрээнд Хан-Уул дүүргийн Соёлын ордноор үйлчүүлж байгаа иргэд хүүхэд залуучуудын дунд Цэвэр орчин бидний ирээдүй танилцуулах ажлыг зохион байгуулсан. Үйл ажиллагаанд 760 иргэн хамрагдсан.	70
4.4.1 Дүүргийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулна.				
109	3.75 Үндсэн чиглэл 4-23 Дүүргийн иргэдийн спортын VIII их наадмыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хан-Уул дүүргийн Иргэдийн спортын VII их наадмыг спортын 7 төрлөөр зохион байгуулахаар төлөвлөн шаардагдах төсвийг батлуулсан. Их наадмын анхан шат болох Хороодын аварга шалгаруулах тэмцээнийг 05 дугаар сарын 15-аас 08 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулахаар төлөвлөөд байна. 05 дугаар 27-ны байдлаар 3 хороо спортын / сагсан бөмбөг, волейбол/ 2 төрлөөр анхан шатны тэмцээнээ зохион байгуулсан.	40
4.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.				
110	3.76 Үндсэн чиглэл 4-24 Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжин улс, нийслэлийн шигшээ тэмцээнд амжилттай оролцуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Дүүргийн Засаг даргын дэргэд Өсвөрийн шигшээ багийг спортын 10 (сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөг, чөлөөт, жүдо, дугуй, бокс, тэшүүр, ширээний теннис, софт теннис) төрлөөр 10 дасгалжуулагч, 225 тамирчин, нийт 236 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид эхний хагас жилийн байдлаар улс, нийслэл, нэрэмжит тэмцээнээс алтан медаль-54 мөнгөн медаль -59 хүрэл медаль-79 нийт 192 багц медаль хүртсэн. Шигшээ багийн дасгалжуулагчын цалинд 16.000.000 төгрөг зарцуулаад байна.	60
.4.3 Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлийн уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна.				

111	3.77 Үндсэн чиглэл 4-25 Хүүхдийн спортын наадмыг дүүргийн хэмжээнд зуны спортын төрөл болон паралимп, дифлимкийн төрлөөр зохион байгуулна.	Спортын төрөл, тоо	Монголын Хүүхдийн спортын VI их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг Гүйлтийн тэшүүр, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, жүдо, шатар гэсэн спортын 20 төрлөөр зохион байгуулж 22 сургуулийн 2962 сурагчдыг хамруулж 9,220,300 төгрөгийг зарцуулаад байна. Мөн хүүхдийн спортын их наадмын гүйлтийн тэшүүрийн шигшээ тэмцээнд 6-р байрт шалгарсан. Хүүхдийн спортын их наадмын бусад төрлүүд 09 дүгээр сард зохион байгуулагдана.	80
112	3.78 Үндсэн чиглэл 4-26 Бүх ард түмний спортын наадмыг дүүргийн хэмжээнд өвлийн спортын төрлөөр зохион байгуулна.	Спортын арга хэмжээ, тоо	Монголын бүх ард түмний өвлийн спортын XVI их наадамд 12 багийн 126 тамирчин оролцсон бөгөөд дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг шайбтай хоккей, шорт рейк гэсэн 2 төрлөөр зохион байгуулж, их наадмын шигшээ тэмцээнд шайбтай хоккейн тэмцээнд 3-р байр, шорт рейкийн тэмцээнд 2-р байрт тус тус шалгарч, байгууллагын нэгдсэн дүнгээр 4-р байрт шалгарсан.	100
113	3.79 Үндсэн чиглэл 4-27 26 дугаар сургуулийн спорт заалны барилгыг шинээр барих, дүүргийн спорт хорооны бялдаржуулах танхимын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Ажлын явц, хувь	26 дугаар сургуулийн спорт заалны барилгыг шинээр барих ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 2019 оны 03 сарын 27-нд зарлагдсан. 05 сарын 09-нд нээлт хийсэн бөгөөд тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. Дүүргийн спорт хорооны бялдаржуулах танхимын тохижилтын ажлын тендер 2019 оны 05 сарын 09-нд зарлагдаж, 05 сарын 17-нд нээлт хийсэн. Тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна.	40
4.4.4 Усан спорт сургалтын төв нэмж байгуулна.				
114	3.80 Үндсэн чиглэл 4-28 "Усан спорт сургалтын төв"-ийн нэг маягийн зургийн холболтын зургийг шинээр хийлгэж, хөрөнгийн эх үүсвэрийг улс, нийслэлийн төсөвт тусгах санал боловсруулан уламжилна.	Ажлын явц, хувь	Дүүргийн Засаг даргын 2019 оны 02 сарын 25-ны А/56 дугаар захирамжаар усан спорт сургалтын төвийн зураг төсөв хийлгэх 50,0 сая төгрөгийн төсөв баталсан. Газрын судалгаа хийгдэж байна.	30
4.5.1 Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөрийг үндэсний өв уламжлал, ёс заншилтай хослуулан хэрэгжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, боловсролтой, амьдрах ухаантай, эх оронч, иргэнийг төлөвшүүлнэ.				
115	3.81 Үндсэн чиглэл 4-29 Үндэсний өв уламжлал, ёс заншлаа дээдлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор "Бид Эко дүүргийн хүүхдүүд" хүүхдийн чуулган зохион байгуулна	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	Монгол улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд "Хүүхдээ сонсох өдөр"-ийг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Ерөнхий боловсролын 16 сургуулийн 130 төлөөлөгч хүүхдүүд оролцон "Сургуулийн орчин", "Гэр бүлийн орчин", "Нийгмийн орчин", "Цахим орчин" 4 сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлаа ярилцан, өөрсдийн санал хүсэлтийг илэрхийллээ. Үйл ажиллагаанд дүүргийн Засаг дарга болон	100

			холбогдох хэлтэс, албадын дарга нар оролцож сурагчдын асуултад хариулж өмнөх үйл ажиллагааны явцад гарсан саналыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар мэдээлэл өглөө.	
4.5.2 Хүүхдийн зуслан, тоглоомын талбай, биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална.				
116	3.82 Үндсэн чиглэл 4-31 "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичигт заасны дагуу дүүрэгт байгуулах хүүхдийн зуслангийн зураг төсвийг магадлалаар оруулж шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улс, нийслэлийн төсөвт тусгах санал боловсруулан уламжилна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	13-р хорооны нутаг дэвсгэрт 5.0 га газарт төлөвлөн, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар хүссэн боловч Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хилийн заагийг тодруулах шаардлагатайг мэдэгдсэн. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хилийн заагийн тодруулга хүссэн боловч ажлын хэсгийн дүгнэлтээр баталгаажуулж өгнө гэсэн хариу ирсэн.	10
117	3.83 Үндсэн чиглэл 4-32 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт төсөл хэрэгжүүлэх газрын талаар тодруулга авах албан бичиг хүргүүлсэн. НЗДТГ-ын ХЭЗХ-ээс "Эс Си Эм" ХХК-д эзэмшүүлсэн 44758 м2, 38393 м2 газрыг Газрын тухай хуулийн 40.1.6-д заасан үндэслэлээр НЗД-ын 2018 оны А/792 дугаар захирамжаар хүчингүй болгосон бөгөөд одоогоор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа гэсэн хариу ирүүлсэн. 41-р сургуулийн өөрийн эзэмшлийн 7300 м2 газарт тохижилтын ажил хийх хүсэлтийг 06-р сарын 04-ний 06/348 дугаартай албан бичгээр УИХ-ын гишүүн Л.Болдод хүргүүлээд байна.	20
4.5.3 Дүүргийн хэмжээнд "Хүүхдийн авьяас төв" таваас доошгүйг байгуулна.				
118	3.84 Үндсэн чиглэл 4-33 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад "Хүүхдийн авьяас төв"-ийг нээнэ.	Нээгдсэн төв, тоо	Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Хүүхдийн урлан бүтээх төвийн салбар дугуйланг сүлжмэл наамлын хичээлээр 114 дүгээр сургуульд, Монголын хүүхдийн ордны салбар дугуйланг зургийн хичээлээр 2 дугаар хороонд байгуулан нийт 85 сурагч төгссөн. Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор хороодод, Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн 16 төрлийн дугуйлан ажиллуулахаар төлөвлөгөө гарган Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газарт 2019 оны 02 сарын 25 өдөр хүргүүлсэн. Дугуйланг хичэллүүлэх багш нарын цагийг зеруулэн хуваарь гаргахаар ажиллаж байна.	50
4.5.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсэн хүүхдийн тоог бууруулна.				

119	3.85 Үндсэн чиглэл 4-34 Хүүхдийг цахимын хор нөлөөлөл, хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх зорилгоор "Хүүхдээ хамгаалахад эцэг эхийн оролцоо" сарын аян зохион байгуулна.	Зохион байгуулах аян, тоо	Хугацаа болоогүй	-
4.5.6 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх санал санаачилгыг өрнүүлж, "Хүүхэд, гэр бүлд ээлтэй" байгууллага, үйлчилгээ, орчныг шалгаруулан, олон нийтэд сурталчилна.				
120	3.86 Үндсэн чиглэл 4-37 Хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн санал санаачлагыг өрнүүлж, "Хүүхэд, гэр бүлд ээлтэй" үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ.	Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ, тоо	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд уриалгыг хүргүүлсэн. Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр 6 аж ахуйн нэгж байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д эцэг эхийн зөвлөл байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Улаанбаатар ОУИС-ын багш Д.Оюун-Эрдэнэ, дүүргийн ГБХЗХХ, АБНТБТ хамтран "Гэр бүлийн боловсрол, хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг зохион байгуулсан.	40
4.5.7 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үүнээс ажлуудыг эрчимжүүлнэ. татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх сурталчилгаа нөлөөллийн				
121	3.87 Үндсэн чиглэл 4-39 Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд сургалт зохион байгуулна.	Сургалт, тоо	Хороодын хамтарсан багийг чадваржуулах, иргэдэд жендэрийн тухай хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл өгөх нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийг хангах хүрээнд хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг 2 удаа, кейс хэлэлцүүлгийг 4 удаа, иргэдэд мэдээлэл өгөх сургалтыг 33 удаа нийт 35 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 1069 иргэнийг хамруулсан.	100
4.6.1 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, соён гэгээрүүлэх, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулж, дугуйлан клубуудыг шинээр байгуулахыг дэмжинэ.				
122	3.88 Үндсэн чиглэл 4-40 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хороодын дэргэд Залуучуудын дугуйлан, клуб байгуулан залуучуудын санал санаачилгыг дэмжиж ажиллана.	Дугуйлан, клубын тоо	Иргэдийг эрүүл мэндийг хөдөлгөөнөөр дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, чийрэгжүүлэх зорилгоор Залуучуудын Хан-Уул клубын бүжгийн баг тамирчидтай хамтран Залуучуудын явган аяллын клубийг 9, 10 дугаар хороодод байгуулсан. Клуб 30 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлэн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн ажлуудыг хийж байна. Мөн эмэгтэйчүүдийн бүлэг явган аялалын клубыг байгуулан Богд	40

			уул, Жаргалантын ам, Сонгинохайрхан ууланд явган аялалыг 4 удаа зохион байгуулсан.	
123	3.89 Үндсэн чиглэл 4-41 Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг хангах зорилгоор "Иргэдийн хөгжлийн төв"-ийг барих ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дахь 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 12 дугаар хороонд Иргэдийн хөгжлийн төвийн барилга баригдахаар батлагдсан. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжих газрын асуудлыг шийдвэрлэх талаар дүүргийн Газрын албанд 06/558 тоот албан бичиг хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 04 өдрийн А/204 газар эзэмших захирамж гарсан. Газрын гэрчилгээ хүлээгдэж байна.	20
124	3.90 Үндсэн чиглэл 4-44 Ахмад, залуучуудын хөгжлийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Худалдан авах ажиллагааны эрх НЗД-ын 2019 оны А/316 дугаар захирамжаар НХААГ-т шилжсэн. АТД, зургийн даалгавар боловсруулахад газрын гэрээ, гэрчилгээ шаардлагатай бөгөөд ТОСК-ийн эзэмшил газарт барихаар төлөвлөж байна.	10
4.6.4 Залуусын дунд мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааны арга хэмжээг цагдаагийн байгууллагуудтай хамтарч байнга зохион байгуулна.				
125	3.91 Үндсэн чиглэл 4-45 Залуусын дунд мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт, тоо	Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаа. Уг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисын хор нөлөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтыг 5 удаа зохион байгуулж Ерөнхий боловсролын 32, 59, 60, 115, 118 дугаар сургуулийн нийт 15 багш, 20 эцэг эх, 308 сурагч тус тус сургалтанд хамрагдаж, 25 нэр төрлийн 300 ширхэг хууль тогтоомжийн боршур, хууль зүйн лавлах утасны нэрийн хуудас 350 ширхэг тарааж ажилласан.	50
4.8.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулна.				
126	3.92 Үндсэн чиглэл 4-50 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж, стандартын дагуу засаж сайжруулах ажлыг шат дараатайгаар судалж, шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хугацаа болоогүй	-
4.8.2 Төрийн үйлчилгээний болон төсөлт ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж ажиллана.				
127	3.93 Үндсэн чиглэл 4-51 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн харилцаанд оролцох тэгш	Зохион байгуулах үйл ажиллагаа, тоо	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд "Эрүүл аз жаргалтай ирээдүй" өдөрлөгийг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт Хан-Уул дүүргийн хөгжлийн	40

	эрхийг хангах зорилгоор төрийн байгууллага, иргэн, ААНБ-ын идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.		бэрхшээлтэй 512 хүүхэд, тэдний эцэг эх оролцож, боловсрол, эрүүл мэнд, халамж, хамгааллын үйлчилгээг газар дээр нь үзүүллээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эцэг эхчүүдэд мэргэжлийн сэтгэл зүйч зөвлөгөө өгч, хүүхдийн бэрхшээлд тохирсон спортын 5 төрлийг танилцуулсан. Уг арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхчүүдийн холбоо, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Гүүд нейборс ТББ, зэрэг байгууллагууд хамтран ажиллаа.	
4.8.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, алдаа дутагдлыг цаг тухай бүр нь илрүүлэн шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.				
128	3.94 Үндсэн чиглэл 4-54 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хугацаа болоогүй	-
9.1 Ахмадын сувилал, асрамжийн газруудыг шинээр байгуулна.				
129	3.95 Үндсэн чиглэл 4-55 Ахмадын сувиллын барилгын зураг төсвийг батлуулж, барилгын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувь	Ахмадын сувилалын барилгын ажлын зураг төсвийг “Эм Эс Эл” ХХК гүйцэтгэж байна. Зураг төсвийн ажлын гүйцэтгэл 80 хувь	20
4.9.2 Ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.				
130	3.96 Үндсэн чиглэл 4-56 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах шаардлагатай ахмадын судалгаа гаргаж үе шаттайгаар эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.	Хамрагдалт, хувь	Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 16 хорооны ӨЭМТөвүүд дээр 7 хоног бүрийн Баасан гаригт ахмад настныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар хуваарь гаргасан бөгөөд 13 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт оны эхний хагас жилийн байдлаар нийт давхардсан тоогоор 7735 ахмадыг хамруулаад байна. Тус хуваарийн дагуу үзлэгийг жилдээ нэг хороон дээр 2 удаа үзлэг хийхээр төлөвлөсөн.	50
4.9.3 Ахмадуудад зориулсан үйлчилгээний жишиг стандартыг боловсруулж дүүргийн төр захиргааны байгууллагуудаас эхлүүлэн нэвтрүүлж ажиллана.				
131	3.97 Үндсэн чиглэл 4-57 Дүүргийн төр захиргааны байгууллагуудын байрыг ахмад настанд ээлтэй үйлчилгээний жишиг болохуйц тохижилттой болгох ажлыг эхлүүлнэ.	Ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллага, тоо	Хугацаа болоогүй	-
4.9.4 Нийтийн тээврийн болон үйлчилгээний байгууллагуудад ахмадын үйлчилгээний тусгайлсан стандарт, тэмдэг тэмдэглэгээг бий болгож хэвшүүлнэ.				
132	3.98 Үндсэн чиглэл 4-58 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний	Ээлтэй орчин бүрдүүлсэн ААНБ, тоо	Хугацаа болоогүй	

	байгууллагуудад ахмадын үйлчилгээний тусгайлсан стандарт, тэмдэг тэмдэглэгээг бий болгож хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.			-
4.9.5 Ахмадуудыг нийгмийн амьдралд оролцох, өөрсдийн мэдлэг туршлагаа залуу үетэйгээ хуваалцах боломжийг хангах үүднээс “Ахмад үеэсээ суралцъя” төсөлт арга хэмжээг зохион байгуулна.				
133	3.99 Үндсэн чиглэл 4-59 Ахмадуудыг нийгмийн амьдралд оролцох, өөрсдийн мэдлэг туршлагаа залуу үетэйгээ хуваалцах боломжийг хангах зорилгоор “Үнэ цэнэтэй ахмад-Эко хуримтлалын бүл” төслийг хэрэгжүүлнэ.	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	“MSDI Шинэ Хөгжлийн Түлхүүр” ТББ-тай 2018 оноос эхлэн хамтран ажиллаж “Үнэ цэнэтэй ахмадууд-Эко ахмадын хуримтлалын бүл” төслийг хэрэгжүүлж 5 удаагийн сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 442 ахмадыг хамруулсан бөгөөд 3 ахмадын бүлэг үүссэн. 2019 онд “MSDI Шинэ Хөгжлийн Түлхүүр” ТББ тус 3 ахмадын бүлгүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлж байна.	70
5.1.1 Засаг захиргааны анхан шатны нэгж-хорооны төсөв санхүү, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлнэ. Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлнэ.				
134	3.100 Үндсэн чиглэл 5-1 Дүүргийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлэх” ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сантай хамтран хороодод төрийн үйлчилгээг шилжүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Үйлчилгээ, тоо	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Азийн сантай хамтран хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, хороодоос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн 7 дугаар хороо сонгогдон нийслэлийн Архивын газрын 3, нийслэлийн Улсын бүртгэлийн 1 үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилийн байдлаар 231 иргэнд мэдээлэл лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн. Төвөөс алслагдмал суурьшиж буй иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, иргэдийн эрэлт хэрэгцээ, төвлөрлийг сааруулах зорилгоор иргэдээс хорооны үйлчилгээнд цаашид нэмж оруулах хүсэлтэй үйлчилгээний төрлүүдийн судалгааг 16 хороодын иргэдээс авсан. Судалгаанд нийт 855 иргэн хамрагдсанаас 9 төрлийн төрийн үйлчилгээг нэмж авахыг хүссэн байна. Иргэдийн 25% нь Газар зохион байгуулалтын албаны үйлчилгээ, 20% нь Нийгмийн даатгалын үйлчилгээ, ТҮЦ машин байршуулах, 12% нь гадаад паспорт захиалах үйлчилгээг хорооноос авах саналаа ирүүлсэн. Судалгааны талаарх нэгдсэн дүн мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 04/1222 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	50
5.1.2 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого хэрэгжүүлнэ.				
135	3.101 Үндсэн чиглэл 5-2 Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	“JCI Улаанбаатар байгууллага”, “Хүрээ ротари клуб”, “Дэлхийн зөн Монгол” Хан-Уул орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, “Гүүднэйборс” Яармаг орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй тус	100

	байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.		тус хамтран 10 гаруй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
ДӨРӨВ. “ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ-ХӨГЖЛИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД				
51. Цахилгаан бага зарцуулдаг халаалтын дэвшилтэт технологийг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор “Байгальд ээлтэй техник технологи”-ийн үзэсгэлэн зохион байгуулна.				
136	4.1 “Байгальд ээлтэй техник технологи” –ийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан тоо	Байгальд ээлтэй техник технологийн үзэсгэлэн худалдааг 2019 оны 06 дугаар сарын 15-нд зохион байгуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан.	50
54. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн чиглэлээр хамтарч ажиллана				
137	4.2 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлэгт иргэдийн оролцоотой хөндлөнгийн хяналт тавьж ажиллах замаар гэрэлтүүлгийн асалтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	Гэрэлтүүлгийн чиглэлээр иргэдээс болон шуурхай удирдлагын төвөөс ирсэн өргөдөл гомдлыг дуудлагын бригад гарган хурдан шуурхай засварлан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалтыг сар бүр хорооны Засаг дарга нараар гарын үсэг зуруулан баталгаажуулж асахгүй байсан 1496 гэрэлтүүлгийн толгойн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2019 оны 06 дугаар сарын байдлаар гэрэлтүүлгийн асалт 98%-тай байна.	98
55. Гэрэлтэй хот аяны хүрээнд “Гэрэлт гудамжийг байгуулна.				
138	4.3 Иргэд оршин суугчдын саналыг үндэслэн, Гэрэлт гудамж байгуулах байршлыг судлан тогтоож, дүүргүүдэд гэрэлт гудамжийг бий болгох	Жишиг гудамжны тоо	Гэрэлтэй хот” аяны хүрээнд иргэд оршин суугчдын саналыг үндэслэн 15 дугаар хорооны Гандийн гудамжийг гэрэлт гудамж болгон тохижуулахаар шийдвэрлэсэн. Гэрэлт гудамж байгуулахад шаардагдах төсвийг боловсруулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.	50
56. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, байгууллагын гадна фасад, ногоон байгууламжийн гэрэлтүүлэг чимэглэлийг нэмэгдүүлнэ.				
139	4.4 Иргэдийн саналыг үндэслэн төр хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн эзэмшлийн гудамж зам талбай байгууллагын гадна фасад ногоон байгууламжийн гэрэлтүүлэг чимэглэлийг нэмэгдүүлнэ.	Гадна фасад ногоон байгууламжийг гэрэлтүүлсэн ААНБ-ын тоо	Наадамчдын зам дагуух нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд 4752 ширхэг шилмүүст модны ногоон гэрэлтүүлгийг шинээр хийсэн. Чингисийн өргөн чөлөөний гудамжинд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж байгууллагад гадна фасадны гэрэлтүүлгийг сайжруулах талаар уриалга хүргүүлсэн. 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 8 аж ахуйн нэгж байгууллагатай уулзан санал солилцож Бармаш, ploris, Хан-Уул tower, Анун төв гэх мэт аж ахуйн нэгж байгууллагууд гадна фасадны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн сайжруулахаар болсон.	70
57. Өвөрмөц шийдэл бүхий “Жишиг гэрэлт гудамж”-тай болно				
140	4.5 Иргэд оршин суугчдын саналыг үндэслэн, Гэрэлт гудамж байгуулах	Гэрэлтэй гудамжны тоо	Гэрэлтэй хот” аяны хүрээнд иргэд оршин суугчдын саналыг үндэслэн 15 дугаар хорооны Гандийн гудамжийг гэрэлт гудамж болгон тохижуулахаар шийдвэрлэсэн. Гэрэлт гудамж	50

	байршлыг судлан тогтоож, дүүргүүдэд гэрэлт гудамжийг бий болгох		байгуулахад шаардагдах төсвийг боловсруулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.	
68. Ойн төгөл бүхий хороололтой болно				
141	4.6 Орон сууц хороолол дунд ойн төгөл байгуулах байршлын судалгааг гарган иргэд СӨХ-ны оролцоотой зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	Дүүргийн орон сууц хороолол дунд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 3 байршилд бичил ногоон төгөл байгуулах ажил 80%-тай явагдаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хийгдэж байна. 10 дугаар хороо 61, 62 дугаар байрны гадна талбайн цэцэрлэгт хүрээлэнгийн ажил болон Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлууд 80%-тай явагдаж байна. Тус ажлын гүйцэтгэлд техник хяналтын комисс тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	80
74. “Нэг хот- Нэг стандарт” зорилт хэрэгжиж явган хүний зам талбайг нэмэгдүүлнэ				
142	4.7 Газар ашиглалтыг сайжруулах газрын зөрчил арилгах, явган зам, орц гарцыг чөлөөлөх арга хэмжээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Ажлын явц хувиар	Нэг хот- Нэг стандарт аяны хүрээнд дүүргийн Засаг даргын А/367 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагуулж газар чөлөөлөх шаардлагатай 16 байршил, шинээр явган зам хийх шаардлагатай 52 байршлын судалгааг нийслэлийн дэд ажлын хэсэгт хүргүүлсэн. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн 34 байршлын 7797м2 талбайд шинээр явган зам хийхээр шийдвэрлэсэн. 2019 оны 05 сарын 15-ны дүүргийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж 2019 оны 05 сарын 28-ны өдөр гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах тендер зарлагдсан.	50
75. Сайжруулсан түлшний борлуулалтын цэгүүд бий болно				
143	4.8 Борлуулалтын цэгүүдийн байршлыг тогтоож, бий болгон, үйл ажиллагааг жигдрүүлэх	Байгуулсан цэгийн тоо	Үндэсний хорооноос дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 16 дугаар хороонд нийт 61 цэгт сайжруулсан түлшний төвлөрсөн агуулах байгуулахаар болсон.	70
77,78, 79: “Эрүүл шүд – Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх				
144	4.9 Иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааг зохион байгуулах	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, сургагч багш бэлтгэх сургалтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Амны хөндийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, АШУУИС-ийн багш нартай хамтран зохион байгууллаа. Сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч 100 хүнийг хамруулан гарын авлагаар хангасан. Шүдний кабинетэд ирж эмчилгээ хийлгэж байгаа 2016 хүүхдэд видео болон биечлэн муляж дээрх сургалтыг хийсэн. Хөтөлбөрийн жилийн төлөвлөгөө 58%-ийн биелэлттэй байна.	70
145	4.10 Нийслэлийн 9 дүүргийн 02-12 насны хүүхдийн судалгааг хороодоор гаргах	Хүүхдийн тоо	1-р хороонд 2671, 2-р хороонд 3581, 3-р хороонд 5185, 4-р хороонд 2930, 5-р хороонд 1339, 6-р хороонд 1468, 7-р хороонд 1103, 8-р хороонд 2567, 9-р хороонд 2335, 10-р хороонд 3556, 11-	100

			р хороонд 5184, 12-р хороонд 1380, 13-р хороонд 905, 14-р хороонд 1223, 15-р хороонд 7242, 16-р хороонд 3354, нийт 46023 хүүхдийн судалгааг гаргасан.	
146	4.11 Судалгааны дагуу амны хөндийн үзлэгийг зохион байгуулах	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	Амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 5 цэцэрлэгийн 2286 хүүхэд, 8 сургуулийн бага ангийн 7492 сурагч хөгжлийн бэрхшээлтэй 118 нийт 9896 хүүхэд буюу 2-12 насны хүүхдийн 21,5 хувь нь хамрагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгээс өвчлөл илэрсэн 568 хүүхдийг эмчилгээнд хамруулж, үзлэгт хамрагдсан нийт хүүхдийн шүдэнд эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй Бразил улсад үйлдвэрлэсэн фторт түрхлэгийг түрхсэн.	70
103, 104. “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах				
147	4.12 Зорилтот өрхийн хөгжлийн дэмжих” болзолт уралдаан зарлаж дүгнэх	Дэмжлэг авсан өрх, иргэний хувь	Хөтөлбөрт хамрагдсан 987 өрхийг хариуцан ажиллах дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад зорилтот өрх бүрээр очиж нөхцөл байдлыг үнэлэн өрхүүдийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус бүрдээ гарган хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлж буй ажлын явцын мэдээллэл солилцох өргөтгөсөн хурлыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд мэдээллээс дүгнэхэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 410, боловсролыг үйлчилгээнд 210, эрүүл мэндийн үйлчилгээнд 790, гэр бүлд чиглэсэн болон мэргэжил олгох сургалтанд 648, нийгмийн хамгааллын үйлчилгээнд 1058 иргэнийг хамруулсан байна. Зорилтот өрхийн 13,3 хувь нь хөгжлийг дэмжигч өрх болж хөгжлийн түвшин ахисан байна.Өрхийн ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хүн амын 30 хувь нь байнгын ажлын байртай болсон байна. Хариуцан ажилласан Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын авч хэрэгжүүлсэн ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэхээр шийдвэрлэсэн бөгөөд Зорилтот өрхийн 12 өрхөд орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, иргэдийн хандив тусламжтайгаар гэр олгосон.	70
148	4.13 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхдийг эрүүл мэнд, нийгмийн халамжийн шаардлагатай үйлчилгээнд хамруулах	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь	“Хан-Уул дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комисс” тайлант хугацаанд нийт 6 удаа хуралдаж 126 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг хэлэлцэн 80 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 12 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 6 хүүхдэд	80

			<p>байнгын асаргаа шинээр тогтоосон. Мөн боловсрол, эрүүл мэндийн талаар зөвлөлгөө мэдээлэл өгч ажилласан. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар салбар комиссын 2019 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулж шаардлагатай бараа, материалаар хангагдсан. “Дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс”-ын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 204 иргэнийг бүртгэн үнэмлэх олгож, 115 иргэнд сунгалт хийж ажилласан. “Иргэдийг түрээсийн болон түр суурьшуулах орон сууцанд хамруулах хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтэй ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ирүүлсэн 24 хүсэлтийг хүлээн авч бүртгэлд нэгтгэсэн. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй нийт 21 иргэний хүсэлтийг дүүргийн Засаг даргын 07/210,07/228,07/332 дугаартай албан бичгээр Төрийн орон сууцны корпорацид, 2 иргэний хүсэлтийг 07/146,147 дугаартай албан бичгээр Нийслэлийн орон сууцны корпорацид тус тус дэмжин уламжилсан. Монгол Улсын ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1,12.4, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.9 заасны дагуу сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Засаг дарга Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй 90-ээс дээш настай болон харьяалах байгууллагагүй, зорилтот өрхийн ахмадуудад хүндэтгэл үзүүлж нийт 2000 ахмадад гарын бэлэг гардуулан өглөө. Дүүргийн 16 хороо тус бүр өөрийн гаргасан хөтөлбөрийн дагуу ахмадуудыг хамруулан урлаг соёл спортын ажлуудыг зохион байгуулсан. Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны зорилтот бүлгийн 50 ахмад настанг Хариг Трейд ХХК-ний ахмадын амралт, сувиллын газарт сувилуулсан.</p>	
ТАВ. ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ				
5.1 Засаг даргаас бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд дүүрэг хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэх, хяналт тавих, шаардлагатай бүх төрлийн мэдээллийг боловсруулан дүгнэлт, санал бэлтгэх ажлыг зохион байгуулж Засаг даргыг мэдээллээр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх				
149	5.1.1 Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд холбогдох хэлтэс, албадын үйл	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хувь	Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засаг даргын 03 дугаар албан даалгавар боловсруулан батлуулж, засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, хороод, ерөнхий	70

	ажиллагааг уялдуулж, хэрэгжилт үр дүнг тайлагнана.		боловсролын сургууль, цэцэрлэгүүд нийт 81 байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн шууд захирагчтай байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээний загварыг шинэчлэн гэрээний хавсралтаар ДЭЗН-ийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулахаар боловсруулж, 22 хэлтэс, албадаас гэрээний төслийг хянаж, хүлээн авсан. Нийслэлийн Засаг дарга дүүргүүдийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй байгаа тул дэргэдэх хэлтсийн төсвийн шууд захирагч нартай гэрээ байгуулах ажил хүлээгдэж байна. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн Захирал, Эрхлэгчтэй байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээний төсөлд дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх санал боловсруулж тусгуулсан.	
5.2 Дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороо, Засаг даргын дэргэдэх, хэлтэс, алба, байгууллагуудаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, шат дамжлагыг багасгах, иргэд, олон нийтийн санал гомдол, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэх талаар ажил зохион байгуулж, хэрэгжүүлэх, тогтмол хяналт тавих;				
150	5.2.1 “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-ээр төрийн үйлчилгээг 16 хороодын иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж, тайланг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах. Дээрх арга хэмжээний хүрээнд иргэдээс гарсан санал, хүсэлтийг судлан түүний мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хугацаа болоогүй	-
5.3 Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалтын бодлого, төлөвлөлтийн хоорондын уялдаа холбоог хангаж боловсруулах, мөрдөх, санхүүгийн бодлогыг нутаг дэвсгэртээ үр өгөөжтэй хэлбэрээр хэрэгжүүлэх зарчмаар төсвийн гүйцэтгэлийг хангуулах, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, биелэлтэд хяналт тавих:				
151	5.3.1 Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг төлөвлөхдөө ЗГ, Нийслэл болон дүүргийн Засаг даргын ҮАХ, хот төлөвлөлт, хөрөнгө оруулалтын холбогдох бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж хэрэгжилтийг хангуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулах хугацаа болоогүй байна. Боловсруулалтыг холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хийнэ.	-
152	5.3.2 Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, нийслэл,		Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавин дүүргийн Татварын хэлтэстэй орон нутгийн төсвийн орлогыг нэр	96

	дүүргийн эдийн засаг нийгмийн зорилтыг биелүүлэхэд төсвийн орлогыг бүрдүүлэх, төрийн сангийн үйлчилгээг байгууллага, иргэдэд оновчтой, түргэн, шуурхай, ил тод, хүртээмжтэй хүргэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах		төрөл, данс бүрээр тулган баталгаажуулж ажилласнаар 2019 оны эхний 5-р сарын төлөвлөгөөгөөр орон нутгийн төсөвт 15 807 403,8 мян төгрөгийн орлого орохоос урьдчилсан гүйцэтгэлээр 15 186 719,6 мянган төгрөг орж, 96,1 хувийн биелэлттэй байж, төрийн үйлчилгээг тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	
153	5.3.3 Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зорилтот өрхийн нийгмийн халамж үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, соёл, боловсрол, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжил, хамгаалал, биеийн тамир, спортын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах		Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс дээр жил хайгч, ажил олоход хүндрэлтэй, зорилтот бүлгийн ажилгүй иргэнд мэргэжил сонгоход нь шаардлагатай ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг ганцаарчилсан байдлаар 119, бүлгээр 982 иргэнд үзүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэн ажилласан. Эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 333 аж ахуйн нэгж байгууллагын 1623 сул чөлөөтэй ажлын байрны зарыг утсаар болон jobnet-hanuuл.mn сайтаар хүлээн авч хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн, бүртгэлтэй 928 иргэнд сул чөлөөтэй ажлын байр санал болгож 510 иргэнийг ажилд зуучилсан. Үүний 357 нь байнгын, 153 нь түр ажлын байранд зуучлагдан ажиллаж байна.	40
5.4 Дүүргийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг Засаг даргад тогтмол мэдээлж байх;				
154	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг улирал бүр тооцож, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн тайлагнаж ажиллана	Хэрэгжилт үр дүнг тайлагнасан давтамж, тоо	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг олон нийтэд сурталчлах зорилгоор үндсэн чиглэлийг эмхэтгэн 200 ширхэг гарын авлага боловсруулж, иргэдэд тараан сурталчилсан Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны 1-р улирлын биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн биелэлтийг тооцож 2019 оны 04 сарын 05-ны өдөр дүүргийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн. /Хэрэгжилт 28.3%/ 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг 07 сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.	40
5.5 Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай холбоо тогтоосон гадаад харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх талаар ажил зохион байгуулах, хяналт тавих;				
155	Гадаадын харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулан	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хан-Уул дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтуудыг удирдлага	80

	хэрэгжилтийг хангуулан ажиллана. Дээрх ажлын хүрээнд Япон Монгол Улсын хоорондын “Сурагч солилцооны хөтөлбөр”, Бүгд найрамдах Солонгос Улсын Хаман сумтай хамтран “Шийгуаны хүлэмж” төсөл хэрэгжүүлнэ.		болгон 2018 оны Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд Япон Улсын Мусашимураяама хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсан аймгийн Хаман сум, Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотын Изгрев дүүрэг, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Эрээн хоттой боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан тэргүүтэй 7 хүний бүрэлдэхүүнтэй албан хаагчид 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд Япон Улсын Мусашимураяама хотод айлчлан хоёр талын хамтын ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар хэлэлцсэн. Айлчлалын үеэр боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашид хоёр тал “Сурагч солилцооны хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, үүний хүрээнд Япон Улсын Мусашимураяама хотын дунд сургуулийн 12-15 насны сурагчид, багш ажилчдын хамт 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөс 8 дугаар сарын 04-ний өдрүүдэд Хан-Уул дүүрэгт хүрэлцэн ирэхээр болов.	
5.6 Нутгийн захиргааны байгууллага болон хорооны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, илэрсэн дутагдлыг арилгуулах, хяналт тавих;				
156	Дүүргийн Засаг даргын дэргэдэх болон Хороодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулж, ажлын хэсгээс зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тоо	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Хэсгийн ахлагчийн ажиллах журам”-ын хэрэгжилт, хэсгийн ахлагч нарын ажил дүгнэж байгаа байдлыг газар дээр нь шалгах, хороодын үйл ажиллагаанд мониторинг хийх тухай Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 04/1059 дугаар албан бичгээр хороодын Засаг дарга нарт хүргүүлсэн. Төлөвлөсөн хуваарийн дагуу 06 дугаар сарын 10-наас 13-ны хооронд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 16 хороодын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	50
5.7 Засаг даргын Тамгын газар, хорооны бүтцийн өөрчлөлт, чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан хүний нөөцийн удирдлага арга зүйгээр хангах, албан хаагчийн мэдлэг боловсрол, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг үе шаттайгаар хангаж, төрийн алба мэргэшсэн, тогтвортой, чадварлаг байх зарчмыг хангаж ажиллах;				

157	5.7.1 Ажлын чиг үүрэг, бүтээмж, уялдааг сайжруулах чиглэлээр албан хаагчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмж, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр ЗДТГ болон дээд байгууллагуудаас зохион байгуулж байгаа сургалт, семинарт чиг үүргийн дагуу холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан мэдээ, мэдээллэр ханган ажиллаж байна.	100
158	5.7.2 Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдыг мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамруулна.		2019 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газраас 2 албан хаагчийг БНХАУ-д зохион байгуулагдсан богино хугацааны сургалтад, 7 албан хаагчийг Япон Улсад төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах сургалтад, БНСУ-д 2 албан хаагчийг хамтын ажиллагаатай дүүрэгт туршлага судлах, 1 албан хаагчийг богино хэмжээний сургалтад тус тус хамруулсан. Мөн удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институттэй хамтран 3 албан хаагчийг богино хугацааны мэргэшүүлэх сургалтад, 10 албан хаагчийг худалдан авах ажиллагааны АЗ-ын сургалтад хамруулсан.	60
159	5.7.3 Засаг даргын Тамгын газрын болон хороодын албан хаагчдын эрүүл мэндийн байдал, орон байрны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.		2019 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газрын 2, хорооны 1 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж нийт 35.000.000 /Гучин таван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	30
5.8 Засаг дарга Үндсэн хууль, бусад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх талаар явуулж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, тогтмол мэдээлж байх механизмыг бүрдүүлэх;				
160	5.8.1 Засаг даргын Тамгын газрын хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим сайтад тогтмол байршуулж, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хан-Уул дүүргийн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, тасгийн хийж хэрэгжүүлсэн цаг үеийн ажлуудыг олон нийтэд сурталчлахаар үйл явдлын мэдээг цаг тухай бүрт нь дүүргийн www.khanuul.mn сайт, Хан-Уул Эко дүүрэг facebook, "Хан-Уул дүүргийн Иргэдийн бүлэг, e-office системд 2019 оны эхний хагас жилийн байдлаар үйл явдлын нийт 512 мэдээ мэдээллийг оруулж ажилласан.	50
5.9 Нутаг дэвсгэрийн удирдлага, дүүргийн хөгжил, нийгэм, эдийн засгийн байдлын талаарх хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээ, олон нийтийн санал, хүсэлтийг судлан боловсруулж, үүнтэй холбогдсон мэдээллийг Засаг даргад тогтмол танилцуулах;				
161	5.9.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, дүгнэлт гарган удирдлагуудад танилцуулах. Судалгааны мөрөөр хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах загварыг хэвлэн нэг цэгийн үйлчилгээний ажилчдаар дамжуулан нийт 120 судалгаа авахуулахаар ажиллаж байна. ЗДТГ-ын даргын санаачилгаар хэлтэс, тасгууд сар бүр 22 айл өрхөөр орж дүүрэгт хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээний талаар иргэдтэй биечлэн уулзаж тулгамдаж буй асуудлуудыг нь сонсон санал, асуулга бөглүүлэн 7 хүлээн авч байна. Дээрх ажлын үр дүнд төрийн үйлчилгээг иргэдэд таниулан сурталчилж, дүүрэгт хэрэгжиж байгаа ажил үйлчилгээний талаар иргэдэд үнэн зөв, бодитой мэдээ, мэдээлэл түгээн ажиллаж байна.	50

5.10 Засаг даргаас иргэд, олон нийттэй харилцах харилцааны менежментийн ил тод, нээлттэй арга хэлбэр, механизмыг бүрдүүлж, байгууллага, иргэд-олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;				
162	5.10.1 Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн иргэдээс гарсан санал хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	Уулзалтын тоо	<p>Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар “Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам” баталсан. Дүүргийн Засаг дарга долоо хоногийн мягмар гарагт шаардлагатай тохиолдолд пүрэв гарагт батлагдсан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзан санал, хүсэлтийг сонсон шийдвэрлэж, хариу өгч байна. Уулзалтаар иргэдээс тавьж буй санал, хүсэлтийг газар дээр шийдвэрлэж, хариу өгөх зорилгоор чиг үүргийн хамааралтай хэлтэс албадын удирдлагуудыг оролцуулж, шийдвэрлэх боломжтой санал, хүсэлтийг шийдвэрлэж байна.</p> <p>2019 оны хагас жилийн байдлаар нийт 10 удаагийн хуваарьт уулзалтаар 85 иргэнийг хүлээн авч, хүсэлтийг нь сонсож хариулт өгсөн. Иргэдийн уулзалтаас гарсан санал хүсэлт болон санал хүсэлтийн биелэлтийг тухай бүр нэгтгэж боловсруулан батлуулж ажилласан.</p> <p>Мөн иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу дүүргийн Засаг даргын 2014 оны 04 сарын 16-ний өдрийн А/111 тоот захирамжаар “Иргэдээс мөнгөн тусламж хүссэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх тухай журамд заасны дагуу хороодын хөгжлийн нийгмийн ажилтныг мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр очиж судлуулан нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн нийт 12 иргэнд 5.000.000 /таван сая/ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна.</p>	50
5.11 Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж, иргэдэд хууль эрх зүйн сургалт сурталчилгааг зохион байгуулах;				
163	5.11.1 Захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөгөө мэдээллээр хангах, Хууль тогтоомжийн мэдээллийн санг шинэчлэн баяжуулж төрийн албан хаагч, иргэдэд хууль зүйн зөвлөлгөө мэдээлэл үзүүлнэ.	Сургалтад, хамрагдаж зөвлөгөө мэдээллээр хангасан албан хаагч, иргэдийн тоо	<p>Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гаргасан Засаг даргын 197 захирамжийн төсөл, 1 журам, 2 хөтөлбөрийг хянаж, хууль эрх зүйн зөвлөмж, зааварчилгаа өгсөн.</p> <p>Эрх зүйн сургалтыг 10 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 106 албан хаагч, ЕБС-ын ахлах ангийн 410 сурагч, 107 иргэдийг хамруулж, 600 ширхэг шинээр батлагдсан боршур тараан, 1.507.500 төгрөгийн төсөв зарцуулан ажилласан.</p>	50
5.12 Засаг даргын болон Тамгын газрын албан хэргийг хөтлөх, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах ажлыг зохион				

байгуулж, гүйцэтгэлтэд хяналт тавих;				
164	5.12.1 Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, EDOC програмын хэрэглээг хэвшүүлэх, системийн хэрэглэгчдийг мэдээлэл арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Засаг даргын Тамгын газарт цаасан болон цахим хэлбэрээр ирсэн 2077 бичгийг хүлээн авч холбогдох удирдлага, хэлтэс, тасагт тухай бүр бүртгэн шилжүүлж, байгууллагаас боловсруулсан 1242 албан бичгийг бүртгэж цаасан болон цахим хэлбэрээр илгээсэн. Дүүргийн хэмжээнд 15413 албан бичиг цахимаар бүртгэн, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн нийт 65 удаагийн мэдээг Засаг даргын Тамгын газар, дүүргийн EDOC цахим програм ашиглагч 92 байгууллагыг хамруулан 7 хоног, сар, улирал, хагас жилээр гаргаж Засаг даргын Тамгын газар, Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн, Нийслэлийн Архивын Газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус танилцуулсан.	50
5.13 Төрийн архивын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, цахимжуулах, мэдээллийн сан, сүлжээг бүрдүүлэн түүний нууцыг хадгалах				
165	5.13.1 Дүүргийн архивын үйл ажиллагааг хэрэгжүүлж, 2018 оны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж, хадгалагдаж байгаа удирдлагаас батлан гаргасан захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн, архивын цахим мэдээллийн хоёрдогч сан үүсгэх, сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн 19 байгууллагын 128 байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нягтлан шалгаж архивлан байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Мөн 2019 онд нөхөн бүрдүүлэлт хийгдэх 12, 27, 28, 29 35, 49 дүгээр цэцэрлэг, 115 дугаар сургуулийн байнга хадгалах хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг гүйцэтгэн хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. Архивын нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт архивын баримтын хадгаламжийн нэгжид тавигдах шаардлага, хадгаламжийн нэгж бүрдүүлэх журмын дагуу арга зүйн зөвлөмжийг өгч шалган туслах ажлыг явуулсан. 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэхэд тавигдах шаардлага”, 03 дугаар сарын 19-ний өдөр “Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулан 134 алба хаагч хамрагдсан.	60
5.14 Засаг даргын захирамж, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, Засаг даргад танилцуулах;				
166	5.14.1 Захирамж, үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилэр хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, удирдлагуудад тайлагнана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2019 оны 01 дүгээр улирлын байдлаар биелэлтийг тооцож мэдээлэх 6 төрлийн 21 захирамжлалын баримт бичгийн холбогдох 76 заалтыг хяналтад авч, биелэлтийг нэгтгэн, батлуулж 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 04/542 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаандаа хүргүүлсэн. /Биелэлтийн дундаж-32%/ Хан-Уул дүүргийн 2019 оны эхний хагас жилийн байдлаар биелэлтийг тооцож мэдээлэх 4 төрлийн 14 захирамжлалын баримт бичгийн холбогдох 54 заалтыг хяналтад авч Засаг	50

			даргын дэргэдэх, хэлтэс, албадад 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 04/1032 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Биелэлтийг нэгтгэн, батлуулж 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд дүүргийн дэргэдэх хэлтэс, албадын захирамжлалын баримт бичгийн биелэлт хариуцан тайлагнадаг нийт 20 албан хаагчдад 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгч ажилласан.	
5.15 Үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө Засаг даргаар, нэгжүүд улирал, жилээр ажлаа төлөвлөж төлөвлөгөөгөө Тамгын газрын даргаар батлуулж ажиллах үүрэг хүлээнэ.				
167	5.15.1 Засаг даргын Тамгын газрын “Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн тайлагнана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Засаг даргын Тамгын газрын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн батлуулсан. Тус төлөвлөгөө нь нийт 6 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 33, “Нийслэлийн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 1, “Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 101, “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд 13, Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 16, бусад ажлын хүрээнд 10, нийт 178 ажлыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 57 хувьтай хэрэгжсэн.	50
Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аж ахуйн талаарх үйл ажиллагааг зохион байгуулах.				
168	5.16.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого явуулж, дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулна.	Зохион байгуулах ажлын тоо	2019 оны 06 сарын 17-ний өдрийн байдлаар Орон нутгийн 10 байгууллагаас эд хөрөнгийн тооллого бүрэн дууссан 3 байгууллага, 80% -ийн гүйцэтгэлтэй 3 байгууллага, 50%-н гүйцэтгэлтэй 3 байгууллага, өнөөдөр эхэлж байгаа 1 байгууллага байна. 06 дугаар сарын 25 -нд бүх байгууллага 100% дуусгах төлөвлөгөөтэй байна.	50
ЗУРГАА. БУСАД АЖИЛ				
А. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ”, ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР				
5.1.4 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлнэ.				
169	6.1 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Тамгын газрын албан хаагчдыг дотоод, гадаадын дунд болон богино	Хамрагдсан албан хаагч, тоо	2019 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газраас 2 албан хаагчийг БНХАУ-д зохион байгуулагдсан богино хугацааны сургалтад, 7 албан хаагчийг Япон Улсад төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах сургалтад, БНСУ-д 2 албан хаагчийг хамтын ажиллагаатай дүүрэгт туршлага судлах,	60

	хугацааны сургалт, семинарт хамруулж мэргэшүүлнэ.		1 албан хаагчийг богино хэмжээний сургалтад тус тус хамруулсан. Мөн удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институттэй хамтран 3 албан хаагчийг богино хугацааны мэргэшүүлэх сургалтад, 10 албан хаагчийг худалдан авах ажиллагааны АЗ-ын сургалтад хамруулсан	
170	6.2 "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж ажиллана.	Дэмжлэг үзүүлсэн албан хаагч, тоо	2019 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газрын 2, хорооны 1 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж нийт 35.000.000 /Гучин таван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	20
В. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ				
171	6.3 Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, Хороодод төрийн архивыг цахимжуулах, мэдээллийн сан, сүлжээг бүрдүүлж, мэргэжил арга зүйгээр хангах, цаасан болон цахимаар ашиглуулсан баримтын нэр төрөл, нэгдсэн тоо бүртгэлийг тайлагнаж ажиллах	Захирамжлалын баримт бичгийн тоо	Дүүргийн Засаг даргын дэргэдэх 104 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч Захирамжлалын баримтыг цахим санд шивж оруулсан 78 байгууллага байна. Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А тушаалыг 01-283 хүртэл цахим санд шивж оруулсан. Монгол улсын Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу лавлагаа хуулбар болон дотооддоо нийт 405 баримтыг түр ашиглуулсан.	50
172	6.4 Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, Хороодын албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн хэрэглэгчдийг мэдээлэл арга зүйн удирдлагаар хангах, Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартыг мөрдүүлж, сургалт зохион байгуулна.	Гүйцэтгэлийн хэрэгжилт хувиар	Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан MNS 5140-2011 стандартыг мөрдлөг болгон ажиллаж, Засаг даргын дэргэдэх хэлтэс, тасгийн албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад зориулсан "Шийдвэрлэгдсэн албан бичгийг хянан батлахад шаардлагатай зааварчилгаа" сэдэвт сургалтыг 2019 оны 01 дүгээр сарын 24, 03 дугаар сарын 19-ний өдөр 2 удаа зохион байгуулж 97 албан хаагч хамрагдсан.	100
С. ИЛ ТОД БАЙДАЛ				
173	6.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан, тайлан мэдээг хугацаанд нь илгээж тайлагнана.	Гүйцэтгэлийн хэрэгжилт хувиар	Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсвийн орлого зарлага өрийн мэдээ болон хөрөнгө оруулалттай холбоотой бүхий л мэдээлэл, 5 саяаас дээш дүнтэй гүйлгээний мэдээлэл болон оруулах ёстой мэдээллүүдийг сар бүр, тухай бүр, хагас улирлаар хагас жилээр хугацаанд нь shilendans.gov.mn сайтад байршуулан ажилласан.	50
174	6.6 www.khanuul.mn, eoffice.khanuul.mn цахим хуудсуудад хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, үүрэг даалгаврын	Гүйцэтгэлийн хэрэгжилт хувиар	Дүүргийн www.khanuul.mn . Сайтад Иргэдийн хурлын тогтоол, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон төсөв санхүүтэй холбоотой бүхий л мэдээллийг хугацаанд нь тухай бүр байршуулан ажилласан.	50


	биелэлтүүдийг тогтмол байршуулж иргэдэд нээлттэй байлгана.			
175	6.7 Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллах, тайлан мэдээг хуулийн хугацаанд мэдээлэх	Гүйцэтгэлийн хэрэгжилт хувиар	Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хороо нь Ёс зүйн зөвлөл болон 2019 онд шинэчлэгдсэн. Ёс зүйн зөвлөл нь 2019 оны ажлын төлөвлөгөөнд албан хаагчдыг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх, сургаж хөгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийт ЗДТГ-ын нийт албан хаагчдад танилцуулж, мэдээллийн самбар болон дүүргийн цахим сайтад байршуулсан. Сургаж хөгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдад 3 удаагийн сургалтыг НЗДТГ болон Удирдлагын академи-тай хамтран зохион байгуулж 58 албан хаагчийг хамруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрлийн мэдээ тайланг хуулийн хугацаанд НЗДТГ-т хүргүүлсэн.	50
D.НИЙСЛЭЛИЙН 380 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ “БҮТЭЭЛЧ АЖЛЫН САНАЛ				
176	6.8 Дүүргийн гэр хороололд “Жишиг гудамж” байгуулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн 5-р хороо Яармагийн 15-р гудамж /370м/, 9-р хороо Буянт-Ухаагийн 17-р гудамж /600м/, 10 дугаар хороо Морингийн 0-р гудамж /550м/, 16-р хороо Тайны задгай /550м/ гудамжнуудад жишиг гудамж байгуулах ажлын зураг төсөв батлагдсан. Тендер зарлагдах шатандаа явагдаж байна.	50
177	6.9 Дүүргийн 12,13 дугаар хороодын гадна талбайг дүйцүүлэх, нөхөн сэргээлт хийх журмаар цэцэрлэгт хүрээлэн болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт 100 метр газарт 100 хайлаас, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт 300 метр газарт 500 хайлаас модыг 2019 оны 10 дугаар сард тарина.	50
178	6.10 Хан-Уул дүүргийн “Чингисийн өргөн чөлөөний гудамж”-ийг хаяг реклам байрлуулахад дагаж мөрдөх журмын тавигдах шаардлагад нийцсэн “Жишиг гудамж” бий болгоно	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын тавигдах шаардлагад нийцсэн хаяг, хаягийн байгууламж бүхий жишиг гудамжийг бий болгох ажлын хүрээнд Чингисийн өргөн чөлөөнд үйл ажиллагаа явуулж байгаа 125 аж ахуйн нэгж байгууллагад хаягийн байгууламжийг буулгаж стандартын дагуу шинэчлэх тухай хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн. Албан шаардлага биелүүлээгүй Нэхмэлийн 3, 4, 7 дугаар байрны 32 аж ахуйн нэгж байгууллагыг хаягийн байгууламжийг албадан буулгасан.Хаяг реклам албадан буулгасан 12 аж ахуйн нэгж байгууллага хаягийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байрлуулсан байна. Чингисийн өргөн чөлөөний нийтийн	80

		эзэмшлийн зам талбайд байрлуулсан 15 ширхэг төмөр сууритай хулдаасан самбарыг буулгаж хураасан.	
--	--	---	--

ТӨЛӨВЛӨСӨН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

Засаг даргын Тамгын газрын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн батлуулсан. Тус төлөвлөгөө нь нийт 6 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 33, “Нийслэлийн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 1, “Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 101, “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд 13, Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 16, бусад ажлын хүрээнд 10, нийт 178 ажлыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 57 хувьтай хэрэгжсэн.

Графикаар харуулбал:



Хүснэгтээр харуулбал:

№	Нийт төлөвлөсөн ажил	ҮҮНЭЭС					
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатандаа явж байгаа	Хэрэгжээгүй	Хойшлогдсон	Хугацаа болоогүй	Хувь
		27	141	-	-	10	57%
178							